

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн хэлтэс нь санхүүгийн төлөвлөлт, бүртгэл, хөрөнгө оруулалт, дотоод хяналтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол улсын хууль тогтоомж, Хууль зүйн яам, Санхүү, эдийн засгийн төв байгууллагуудын болон Хууль сахиулахын их сургуулийн захирлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий хэлтэс юм.

Зорилго: Монгол Улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Шилэн дансны тухай” хууль болон холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж, байгууллагын үндсэн үүрэг зорилтыг ханган биелүүлэх, төсөв зохиох, санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах, хуваарилан зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг явуулах, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

Үндсэн зорилт нь: Хууль сахиулахын их сургуулийн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хангалт үйлчилгээг зохион байгуулахад оршино.

Санхүүгийн үйл ажиллагааны зорилт:

Санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн хүрээнд ажиллана.
- Жил бүрийн төсвийн төслийг Их сургуулийн хэтийн (бизнес) төлөвлөгөөтэй уялдуулан хийж төсөвлөх ба тухайн цаг үетэй холбогдож нэмэгдэн гарах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төсвийн тодотгол хийж батлуулж ажиллана
- Санхүүгийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, түүний хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах зорилго бүхий дотоод хяналтын системийг бий болгож, дохиоллын систем нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Суралцах, сургах, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх болон ажиллагсадын ажил үйлчилгээгээ явуулах ажиллах орчин, шаардагдах техник хэрэгслийг хамгийн сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар сайжруулан хангаж ажиллана.
- Их сургуулийн санхүүгийн холбогдолтой төлбөр тооцоог гэрээ байгуулан гүйцэтгэж өр, авлагагүй ажиллана
- Их сургуулийн Стратегийн бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүгийн зүгээс шаардагдах тооцоо судалгаа, төсвийг боловсруулан батлуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллана.
- Мэдээллийн гадаад, дотоод сүлжээний найдвартай байдлыг хангах, түүний ашиглалтыг сайжруулж, компьютер, техник хэрэгслийн ашиглалтын байдлыг тогтоож, засвар үйлчилгээг тогтмолжуулна.
- Сургалтын төлбөр тооцоог сонсогч оюутан нарт тухай бүр мэдэгдэж, барагдуулах талаар Сургалтын бодлого зохицуулалтын газартай хамтарч ажиллана.

- Их сургуулийн санхүүгийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд хамруулах арга хэмжээ авч ажиллана
- Их сургуулийн сар, улирал, жилийн мэдээ тайланг, хуульд заасан хугацаанд гаргаж, ажиллагсадын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг цаг тухай бүрт нь олгож, тэдний нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг баталгаажуулж ажиллана

Санхүүгийн төлөвлөлтийн хэлтэс нь Хууль зүйн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч 1, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн 1, тооцооны нягтлан бодогч 4, нярав 4, мөнгөний касс 1, нийт 11 хүний орон тооны бүтэцтэй ажилласан.

Тус хэлтсийн ажиллагсад нь боловсролын хувьд магистр 1, бакалаврын дээд боловсролтой 10, мэргэшсэн нягтлан бодогч 1 ажиллаж байгаа ба мэргэжлийн хувьд нягтлан бодогч-эдийн засагч 9, бусад мэргэжилтэй 2 байна.

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН

НЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, заавар журмыг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажилласнаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөвлөгөөт санхүүгийн 2012, 2013 оны баримтын шалгалт, Үндэсний аудитын газрын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаа хэвийн зөрчилгүй дүгнэлт авсан.

Санхүүгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг тогтоосон хугацаанд байгуулж, бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд 4 удаа гаргаж Хууль зүйн ямаар хянан баталгаажуулж, Сангийн яамны Э-тайланд цахим хэлбэрээр шивж оруулсан. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг баримтлан, бүх төрлийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн зарчмаар бүртгэсэн ба хөрөнгийг нэрлэсэн үнээр нь болон анхны өртгөөр нь үнэлж, хөрөнгөнд элэгдэл байгуулан элэгдлийн зардлыг бүртгэсэн.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон их сургуулийн мөнгөн кассын сахилга батыг чандлан сахиж гүйлгээг анхан шатны бүрдэл болсон баримтаар хийж, үлдэгдлийг өдөр тутам гаргуулж, байвал зохих бэлэн мөнгөний хэмжээг 14 хоног тутам тоолж, хяналт тавин удирдлагад танилцуулж хэвшсэн ба “Жижиг мөнгөн сан”-д тогтмол дүүргэлт хийж, тайланг тухай бүр Хууль зүйн яамны Төрийн сангаар хянуулж баталгаажуулан ажилласан.

Бараа материал, мөнгөн хөрөнгийн тайланг хариуцсан нярав нар сар бүр гаргаж, нягтлан бодогч анхан шатны баримтуудтай тулгалт хийж шалган хүлээн авч агуулахын бүртгэлийг баталгаажуулж ажилласан. Мөн хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүрт эд хариуцагчийн карт, тээврийн хэрэгсэл, барилгын хувийн хэрэг, техник тоног төхөөрөмжийн паспортын хөтлөлтийн баяжуулалтыг санхүүгийн тайлантай тулгалт хийж хянаж хэвшсэн.

Нягтлан бодогч нар тайланг хүлээн авч боловсруулан нягтлан бодох бүртгэлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, анхан шатны баримтын бүрдэлтийг нягтлан, хуудас бүрийг дугаарлан товъёог хийн хадгаламжийн нэгж болгон сар бүр үдэж жилийн эцэст архивт шилжүүлсэн.

Санхүүгийн тайланг сар, улирал, жилээр гаргадаг ба 7 хоног бүр зардлын хэтрэлт хэмнэлтэд дүн шинжилгээ хийж, батлагдсан төсвийн хүрээнд зардал хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалт хийлгүүлэх тооцоо судалгааг гарган зохих дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлснээр жилийн эцэст өргүй, авлагыг өмнөх жилээс 11230550 төгрөг буюу 24,9 хувиар бууруулан ажилласан.

Эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа явуулж, улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон хандиваар ирсэн, актлагдсан, шилжүүлсэн хөрөнгүүдийн хөдөлгөөнийг хийж тайлан тэнцэлд тусгасан. Үүнд: Улсын төсвийн санхүүжилтээр 457,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тус сургуулийн үе үеийн төгсөгч, хамтран ажилладаг байгууллага, хувь хүнээс 85,1 сая төгрөгийн тавилга, техник хэрэгсэл, сургуулийн доктор, профессор багш нараас 1,7 сая төгрөгийн ном тус тус хандивласан. Төрийн өмчийн хорооны 2014 оны 193, 195-р тогтоолоор 2803,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, Их сургуулийн захирлын 2014 оны Б/155 тоот тушаалаар 23,7 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тус тус акталж, холбогдох данс бүртгэлээс хасч, устгал хийж хогийн цэгт булсан.

Хууль зүйн сайдын 2014 оны А/71 дүгээр тушаалаар ХСИС-ийн сонсогчийн дүрэмт хувцасны загварыг шинэчлэн батлагдснаар 2014 оны 5-р сарын 20-нд нээлттэй тендер зарлаж 5 компани шалгарч, гэрээний дагуу сонсогчийн хээрийн болон ёслолын дүрэмт хувцас нийлүүлэгдсэн.

Нярав нартай 2014 онд эд хариуцагчийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулж, эд хөрөнгийн хариуцлага хүлээх тухай баталгааг гаргуулан авсан.

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, өр, авлагын мэдээг хугацаанд гарган Хууль зүйн яам, Сангийн яамны Төрийн сангийн газарт хянан баталгаажуулан өгч байсан.

Сургалт-эрдэм шинжилгээг тэгш шударга, үр ашигтай, чанартай, хүртээмжтэй хүргэх нийгмийн шаардлагын үүднээс түүнд үзүүлэх Засгийн газрын санхүүжилт зайлшгүй чухал юм

ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГО


Хууль сахиулахын их сургуулийн санхүүжилт нь гурван эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд: Улсын төсөв, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлого юм. Нийт санхүүжилтийн 97,9 орчим хувь нь улсын төсвөөс санхүүждэг.

Төсвийн санхүүжилт, орлого бүрдүүлэлт

/мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Улсын төсөв	9 692 070,3	9 280 881,4	95,8
2	Үндсэн үйл ажиллагааны орлого	161 900,0	246 340,2	152,2
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	49 980,0	112 814,6	225,7
4	Өмнөх оны хэмнэлтийн орлого	62 768,4	62 768,4	100,0
5	Сургалтын төрийн сангийн орлого		79041,0	
6	Хандив		15889,5	
5	Хөрөнгө оруулалтын санхүүжилт	3 523 900,0	4 362 602, 6	123,8
	Орлогын дүн	13 490 618,7	14 160 337,7	104,9

2014 оны орлогын бүрдэлт




Улс орны эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой төсвийн тодотгол хийгдэж 2014 оны батлагдсан төсвөөс **243,5 сая төгрөг**, улсын төсвийн орлого бүрдээгүй гэсэн шалтгаанаар 187,0 сая төгрөг тус тус хасагдсан. Төсөвт өртөг нь нэмэгдсэн барилгуудын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг “0” дүнтэй болгосонтой холбоотойгоор 2013 оны батлагдсан төсвөөс 900,0 сая төгрөг дутуу санхүүжүүлсэнийг 2014 оны 2-р сард өрийн бичиг/вексел/-ээр 839,5 сая төгрөг олгосоноор орлогын нийт дүн 104,9 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлтийн байдал

/мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Эрх зүйн оюутны сургалтын төлбөр		254,0	
2	Дамжаа, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын төлбөр	62 908,0	126 682,8	201,3

4	Магистрийн сургалтын төлбөр	95 220,0	115 597,1	121,4
5	Докторантурын сургалтын төлбөр	3 772,0	3 806,3	100,9
	Үндсэн үйл ажиллагааны дүн	161 900,0	246 340,2	152,2
6	Хичээл нөхөлтийн орлого		495,3	
7	Дахин шалгалтын орлого		5 279,8	
8	Номын сангийн орлого		278,0	
9	Гэрэл цахилгааны орлого		13 322,6	
10	Хоолны орлого	47 480,0	59 996,9	126,4
11	Бусад орлого	2 500,0	32 669,5	1307,1
12	Хэвлэхийн орлого		772,5	
	Үндсэн бус үйл ажиллагааны дүн	49 980,0	112 814,6	225,7



Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн ба Сангийн сайдын 2007 оны 11 дүгээр тушаалын дагуу 147,3 сая төгрөгийг буцаан авахаар тооцоог гарган холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлээд байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГА

Хугацаа: 2014.12.31				
ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	гүйцэтгэл	үлдэгдэл	Гүйцэтгэл хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14267450,3	14002647,1	264803,2	98,1
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	14267450,3	14002647,1	264803,2	98,1
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	9903950,3	9640044,5	263905,8	97,3
Бараа, үйлчилгээний зардал	8648072,4	8385169,1	262903,3	97,0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4954258,5	4942039,5	12219,0	99,8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд	121977,3	121977,3		100,0
Бараа, үйлчилгээний бусад зардал	3571836,6	3321152,3	250684,3	93,0
Татаас ба урсгал шилжүүлэг	1255877,9	1254875,5	1002,4	99,9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13427850,3	14160337,7	732487,4	105,5
Төсвөөс санхүүжих	9692070,3	9280881,4	411188,9	95,8
Үндсэн үйл ажиллагааны орлого	161900,0	246340,2	84440,2	152,2

Туслах үйл ажиллагааны орлого	49980,0	112814,6	62834,6	225,7
Хөрөнгө оруулалт	3523900,0	4362602,6	-838702,6	123,8
Сургалтын төрийн сан		79041,0	-79041,0	
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого		62768,4	-62768,4	
Хандивын орлого		15889,5	-15889,5	
АЖИЛЛАГСАД БҮГД	495	430	65	86,9
Удирдах	5	13	-8	260,0
Гүйцэтгэх	416	347	69	83,4
Үйлчлэх	74	70	4	94,6

Хууль зүйн сайдын 2012 оны Б/20, 2014 оны А/166 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу цалингийн программаар сар бүрийн 10,25-нд цалинг бодож, цалингийн тооцооны баримтыг хүн бүрээр хэвлэн гаргаж гарын үсэг зуруулан олгосон.

Цалингаас суутгаж байгаа ХАОАТ, НДШ-ийн тооцоо, тайланг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд гарган өгч хэвшсэн ба эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хөтлөлтийг хийж, сар бүр баталгаажуулсан. Мөн их сургуулийн сонсогч оюутан нарын цолны цалинг сар бүр ирүүлсэн ирцийн тодорхойлолт, тушаалын дагуу бодож сонсогч бүрийн харилцах дансанд нь шилжүүлэн олгосон.

Цалингийн бүтцийн судалгаа /сая.төг/



2014 оны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн төсөв өнгөрсөн онтой харьцуулахад 676,7 сая төгрөгөөр нэмж батлагдсан нь Засгийн газрын 2014 оны 332-р тогтоолоор төрийн тусгай албан хаагчдын цалингийн санг 15%-иар нэмсэнтэй холбоотой.


Нийт бие бүрэлдэхүүний дундаж цалин өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдсэн нь дээрх тогтоол, зарим алба хаагч нарын ажилласан жилээс шатлал дэвшсэн, албан тушаал ахисан, үр дүн, үр чадварын нэмэгдэл олгосонтой холбоотой.

**Дундаж цалингийн судалгаа
/төгрөгөөр/**



Их сургуулийн 2014 оны батлагдсан төсвийн 5,9 хувийг тогтмол зардал эзэлдэг ба 2014 оны 07 дугаар сараас цэвэр, бохир усны нэгжийн тариф үнэ нэмэгдсэнтэй холбоотой төлөвлөгдсөн зардлаас хэтэрснийг тогтмол зардал дотроо шилжүүлэн зарцуулж бүлгийн дүнгээр хэмнэлттэй гарсан. Тогтмол зардлын хэрэглээг өмнөх жилтэй харьцуулахад 850 сонсогчийн дотуур байр ашиглалтанд орсонтой холбоотой ашиглалтын талбай нэмэгдснээс түлш халаалтын зардал өссөн.


Тогтмол зардал



**Сургалтын орчинг сайжруулах, техник хэрэгслээр хангах,
алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар**


Их сургууль болсонтой холбоотой багш, сонсогч оюутны тоо нэмэгдснээр орчин үеийн хүчин чадал сайтай техник хэрэгсэл, ширээ сандал зайлшгүй шаардлагатай байсан. Иймээс 297,8 сая төгрөгийн сургалтын техник хэрэгсэл, 98,4 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 36,0 сая төгрөгийн ном, сурах бичиг, 7,4 сая төгрөгийн сургалтын программыг тус тус худалдан авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Гэвч төсвийн хөрөнгийн нөөц, боломжоос хамаарч шаардлагатай түвшинд хүртэл техник хэрэгслийн хэрэгцээ хангагдахгүй байна.

Техник, тоног төхөөрөмжийн байдал



Цахим сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Мэдээлэл технологи, холбооны хэлтэстэй хамтран төсөл боловсруулан 2014-2016 оны төсвийн төсөлд саналаа хүргүүлж төсөв батлагдсны дагуу 2014 онд шаардлагатай техник хэрэгслийн хангалтыг хийж харуул хамгаалалтын камержуулалт, дотоод сүлжээ, хяналтын камержуулалтыг бүрэн хийсэн,

Хувцасны программын холболт тохиргоог хийж ашиглалтад оруулан алба хаагч, сонсогч оюутны мэдээллийг оруулах эхлэлийг тавьсан. Дахин дамжуулах станц, паспорт уншигчийн тоног төхөөрөмжийг худалдан авч ашиглалтад оруулаад байна. Хууль хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд холбогдох бэлтгэл ажил ханган санхүүгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн шилэн кабельтай болох ажлыг бүрэн хийж дуусган ашиглалтад оруулсан.




Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс өрх толгойлсон эмэгтэй болон амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 100 алба хаагчдад 8,6 сая төгрөгний түлээ нүүрсний хөнгөлөлт, 4 алба хаагчдад 29,0 сая төгрөгний орон сууцны дэмжлэг, 46 үйлчилгээний ажилтанд 15,6 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл, дотоод журмын дагуу 65 алба хаагчид 18,9 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг, 31 алба хаагчдад 649,9 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг тус тус олгосон. Мөн багш, алба хаагч, ажилтан, сонсогч нарт зах зээлийн үнээс 30 хувийн хямдралтай үнээр 59,9 сая төгрөгийн халуун хоол цайгаар үйлчилсэн.

Тус сургуулийн өндөр настан ахмадуудад сар шинийн баяр, ахмадын өдрийг тохиолдуулан 9,9 сая төгрөгийн хоол, гарын бэлгээр хүндэтгэл үзүүлсэн ба 25 ахмадуудыг Хэнтий аймгийн Дадал сумын нутагт байдаг "Гурван нуур"-ын амралт, Дорноговь аймгийн Хамрын хийдэд зардлыг хариуцан явуулж амраасан.

Бараа материал худалдан авалт

■ Өмнөд өдөр



Их сургуулийн дотоод журмын дагуу докторын зэрэг хамгаалсан багш С.Гантулга, Р.Баярмагнай, Ж.Нямдулам нарт тус бүр 1,0 сая төгрөг, 3 алба хаагчийн докторын зэрэг горилсон бүтээлийн цалинтай 1-3 сарын чөлөө олгож хөнгөлөлтийг эдлүүлсэн. Мөн багш, алба хаагчдын өөрсдийн туурвисан ном, бүтээлийг мэргэжлийн хичээлд гарын авлага болгох зорилгоор 36,0 сая төгрөгөөр худалдан авсан болон 1,7 сая төгрөгийн номыг хандиваар авч данс бүртгэлд тусган ашиглаж байна.

Их сургуулийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй болох үүднээс Зууны мэдээ, Өнөөдөр, Өдрийн шуудан, Үндэсний шуудан зэрэг өдөр тутмын сонингуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, их сургуулийн үйл ажиллагааны талаар сурталчлах ажлыг тогтмолжуулсан ба гэрээний дагуу өдөр тутмын хэвлэлийг хүлээн авч бүтцийн нэгжийн дарга нарт хүргүүлж сургуулийн нийт алба хаагч нарт мэдээлэл түгээн ажилласан.

Зардлыг хэмнэх үүднээс шатахуун, утас, ариун цэврийн материал олгох норм лимит тогтоон мөрдөн ажиллаж байна.

Их сургуулийн 80 жилийн ойг угтсан бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдсан команд штабын сургалтад 4,1 сая төгрөг, марш тактикийн хээрийн сургалтад 15,2 сая төгрөг, хээрийн дадлага, сургалтанд 49,3 сая төгрөг, Олон улсын эрдэм шинжилгээний хуралд 103,1 сая төгрөг, сургууль төгсөлтийн үйл ажиллагаанд 3,2 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг төсвийн зохих зардлаас шийдвэрлэн, шаардлагатай хөрөнгө материалыг татан авч хангалтыг бүрэн хийж үйл ажиллагааг хэвийн явуулсан.

Баянзүрх дүүргийн Гүнжийн хоолой дахь сургалтын төвд 97.0 сая төгрөгийн бүтээн байгуулалт хийж, санхүүгийн тайланд тусгасан


Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл /мян.төг/



Хөрөнгө оруулалт

Тус их сургуулийн 850 сонсогчийн дотуур байрыг 2014 оны 1-р сард улсын комисс хүлээн авч ашиглалтанд бүрэн оруулж, 2014 оны төсвийн тодотголоор 23,9 сая төгрөг батлагдсны дагуу хяналтын зардлыг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газраас төсөвт өртөг нь нэмэгдсэн барилгуудын санхүүжилтийг “0” дүнтэй болгон царцаасан барилгын жагсаалтад тус их сургуулийн 3000 сонсогч, оюутны хичээлийн төв байрны барилга орсноос шалтгаалан 2014 оны төсвийн тодотголоор уг барилгын ажилд **3,5** тэрбум төгрөг батлагдсныг үндэслэн ажлын гүйцэтгэлийн дагуу **3499,9** сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2013 онд дээрх барилгын санхүүжилт дутуу олгогдсны үлдэгдэл 839,5 сая төгрөгийг векселээр 2014 оны 2-р сард олгож жилийн эцэст Сангийн яамнаас санхүүжүүлж өрийг хаасан.



2013 оны жилийн эцсийн тайлан, 2014 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайлан балансыг хуулийн хугацаанд гарган Хууль зүйн яам, Сангийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлж хянан баталгаажуулан аудитын шалгалтанд хамрагдаж **“Зөрчилгүй”** зэрэг дүгнэлт авсан.

ДӨРӨВ. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, “Төсвийн тухай” хуулийн 2011 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн шинэчилсэн найруулга, салбарын хөгжлийн бодлого, Их сургуулийн дунд болон хэтийн төлөвлөгөө, эрхэм зорилго, “Инновацийг нэвтрүүлж, эрдэм судлалыг дээдэлсэн цахим сургууль болно” зорилго, “Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлыг эхлүүлж, сургалтын материаллаг бааз, холбоо, мэдээлэл, технологийн шинэчлэлийг хийх” зорилт зэрэгт тулгуурлан сургуулийн бүтцийн нэгжийн дарга нараас санал авч нэгтгэн, холбогдох хуулийн заалт, хэсгийг үндэслэн тус их сургуулийн 2015-2017 оны зарлагын төсвийн төслийг зардлын зүйл болон хөтөлбөрт суурилсан байдлаар төлөвлөн, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хөтөлбөр тус бүрээр боловсруулан Хууль зүйн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлж хянуулсны дагуу 2015 оны урсгал зардлын төсвийг 10,4 сая төгрөгөөр батлуулсан.

“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгуулах 2015-2017 оны хөрөнгө оруулалтын төсөөлөлийг “Шинэ цогцолбор хотхон”-ыг кампус хэлбэрээр байгуулах, түүнд суурилуулах тоног төхөөрөмжийн зардалд 43.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөөлөл, судалгаа, үр ашгийн тооцоог объект тус бүрээр /51 хуудас/ гарган Хууль зүйн яаманд хүргүүлнээр 3000 сонсогчийн хичээлийн төв байрны барилгын ажлын үлдэгдэл 20,7 тэрбум төгрөг, гадна инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, ХТП-ийн 1,6 тэрбум төгрөг тус тус батлагдсан.


Хууль зүйн сайдын 2013 оны А/78 дугаар тушаалаар Хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд 3 спорт хороог татан буулган тус их сургуульд нэгтгэхээр

шийдвэрлэсний дагуу 2015 оны төсөвт 90 орон тоо, цалингийн сан, урсгал зардлын тооцоог боловсруулан ХЗЯ, СЯ-нд тус тус хүргүүлэн хянуулсан боловч нэмж батлагдаагүй.

ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 1-р сарын 18-ны өдрийн 17-р тогтоолоор баталсан “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бие даасан байх, ил тод, нээлттэй байх зарчим дээр тулгуурлан өмнөх оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь санхүүгийн мэдээллийн самбар, цахим хэлбэрээр тухай бүр байрлуулсан.

Өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөө гарган их сургуулийн захирлаар баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаж 2014 оны жилийн эцсийн тайлангаар өмнөх оноос авлагыг 11,2 сая төгрөгөөр бууруулсан ба өргүй ажилласан байна. Энэ ажлын хүрээнд өр, авлагын мэдээг байгууллага, хувь хүн, алба хаагч, ажилтан бүрээр гарган санхүүгийн мэдээллийн самбар, цахим хэлбэрээр сар бүр байрлуулан, сар бүр өр, авлагын хэмжээг баталгаажуулан тайлан тэнцэлд үнэн зөв тусгасан зэрэг ажлууд хийгдэж хэвшсэн.



Мөн тухайн жилийн батлагдсан төсвийн зардал хооронд шилжүүлсэн өөрчлөлтүүдийг ажлын 14 хоногийн дотор, 2014 оны санхүүгийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг зардлын хэтрэлт, хэмнэлтийн тайлбарын хамт санхүүгийн мэдээллийн самбарт албан хаагч нарт ойлгомжтой байдлаар сар бүр байрлуулсан.

Монгол улсын “2014 оны Төсвийн тухай” хуулиар батлагдсан их сургуулийн 2014 оны төсвийг байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулан гаргасан сарын хуваарь, 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015-2017 оны төсвийн төсөөллийг Их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан сургуулийн бие бүрэлдэхүүнд тухай бүр мэдээлэл авах боломжоор ханган ажилласан.

Их сургуулийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2014 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын мэдээ/байгууллага, хувь хүмүүс, алба хаагч нараар гарган/, улирал бүрийн санхүүгийн тайланг сургуулийн удирдлага, алба хаагч нарт ойлгогдох байдлаар санхүүгийн зардлыг бүлэглэн гаргаж их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлж, хяналт тавих боломжоор ханган ажилласан.

Их сургуулийн 2013 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн дүгнэлт, зөвлөмжийг бүрэн эхээр нь их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан, мөн сургуулийн захирлын холбогдох удирдлагуудад танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар үүрэг даалгавар авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол улсын хэмжээнд төсвийн орлогын бүрдэлт муугаас 2014 оны зарлагын төсөвт Сангийн яамнаас 4 удаа, Хууль зүйн сайд/Төсвийн ерөнхийлөн захирагч/-ийн эрхийн хүрээнд 1 удаа өөрчлөлт зохицуулалт хийсэн шийдвэр, УИХ, ЗГ-аас төсвийн тодотгол 1 удаа хийж 430,5 сая төгрөг хассан тогтоол, Сангийн сайдын тушаал, зардал хооронд зохицуулалт хийсэн тооцоо, цалин, тогтмол зардлаас бусад зардалд шилжүүлэхгүй байх, үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл хөлс олгохгүй байх Сангийн сайдын албан даалгаварыг

санхүүгийн мэдээллийн самбарт бүрэн эхээр нь алба хаагч нарт мэдээлэл авахад боломжтой үзэгдэх орчин сайтай газарт байрлуулсан.

Их сургуулийн “Элсэлтийн журам”-д шинээр элсэн орох иргэдээс авах бүртгэлийн хураамж, дахин шалгалтын төлбөр, “Хэвлэх цех”-д төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тарифийг шинэчлэн тогтоох ажлын хэсгийг Захирлын тушаалаар томилон зах зээлийн болон өртөг зардлыг тооцон мөрдөн ажилласан. Уг төлбөрийн талаарх мэдээллийг их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан.

Их сургуулийн хэмжээнд мөрдөн ажиллах “Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”-ыг боловсруулан сургуулийн захирлаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

“Улсын төсвийн Хөрөнгө оруулалтаар хийгдэх бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтын талаар үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, Сангийн яамны худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас болон сургуулийн санхүүгийн мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулсан, тендер шалгаруулалтын явцын ил тод байдлыг ханган ажилласан.

Төсвийн урсгал санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа үнийн судалгааг 3-аас дээш бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас авч, харьцуулалтын аргыг хэрэглэн, худалдан авах гэрээ байгуулж, гэрээг актаар дүгнэн худалдан авах үйл ажиллагааг явуулж байна.

Худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр гарган Хууль зүйн яаманд хүргүүлсэн ба эх хувиар нь их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан.

Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан ажилласан.

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
- Нийт зардлын ихэнх хэсэг буюу 97,9 хувийг улсын төсвөөс санхүүждэг; - Одоогийн байршилд хичээлийн болон дотуур байр, спортын ордон зэрэг барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон буцалтгүй тусламжаар шинээр баригдах нөхцөл бүрдсэн нь бусад их, дээд сургуультай харьцуулахад цогцолбор хэлбэрээр баригдаж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулах боломжтой; - Сургалт, эрдэм шинжилгээ явуулах сургалтын орчин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавилга эд хогшлийн хангамж сайжирсан; - Сонсогч, оюутан нарын дадлагын хичээл явуулах сургалтын бааз байгуулах газартай болсон - Суралцагч, төгсөгчид тодорхой хандив өгдөг нь сургалтын орчин нөхцлийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд зохих байдлаар нөлөөлсөн;	- Төсвийн орлогын эх үүсвэрийн нэг хэсэг болох өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө өндөр батлагддаг тул биелэгдэхгүй тохиолдолд төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрдэг; - Хичээлийн байрууд, биеийн тамирын заал, зоогийн газрын барилгууд хуучирсан, ашиглалтын зардал их, автомашины гражийн байргүй; - Төсөвт урсгал засвар, эд хогшил худалдан авахад зарцуулах хөрөнгө бага хувийг эзэлдэг; - Багш, алба хаагч, сонсогч оюутан нарын сурч, ажиллах, амьдрах орчин бүрдээгүй; - Сонсогч, оюутны 90 гаруй хувь нь 18-21 насны эрэгтэйчүүд тул зарим эд хогшлын эвдрэл, гэмтэлд зохих хэмжээгээр нөлөөлдөг
Гадаад орчны шинжилгээ	
Боломж	Бэрхшээл

• Төсөвт зардлыг улсын төсвөөс 100% санхүүжүүлдэг болгох • Улсын төсвийн хөрөнгөөр хүчний хичээл явуулах, бэлтгэл хийх спортын ордон барьж ашиглалтанд оруулах • Сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг гадаад, дотоодын их, дээд сургуулиудын жишигт хүргэх хүрээнд дээд шатны байгууллагын зүгээс сүүлийн жилүүдэд анхаарч санхүүгийн нэмэлт хөрөнгийг хуваарилах болсон • Их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд дотоодоос хандив, тусламж, дэмжлэг авах боломжтой	• Цэрэгжисэн байгууллага гэсэн шалтгаанаар олон улсын зарим байгууллагын дэмжлэг авах, төсөл хэрэгжүүлэх, сургалтанд хамрагдах боломж хязгаарлагдмал. • Мэдээлэл дутмаг орчинд ажиллаж буйн улмаас оюуны сүлжээ үүсгэх, улмаар давуу талаараа хорших, хамтран ажиллах, үйл ажиллагаагаа нэгтгэх, туршлага солилцох боломж хязгаарлагдмал; • Өрсөлдөөн дутмаг учир хөгжил удаашрах хандлагатай • Гадаад хамтын ажиллагаа хөгжөөгүй
--	--

Дүгнэлт:

Агентлагуудын захиалгаар цагдаа, хилийн алба, шүүхийн шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, онцгой байдлын байгууллагуудад мэдлэг чадвартай боловсон хүчинг бэлтгэх явцад улс орны эдийн засгийн одоогийн хүндрэлээс төсөв санхүүгийн хувьд саатал гарч, батлагдсан төсвийн хэмжээнд зардлыг бүрэн санхүүжүүлээгүйгээс 2014-2015 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу хийгдэх зарим арга хэмжээнүүд зохион байгуулагдаагүй нь сургалтын үйл ажиллагаа, чанарт сөргөөр нөлөөлсөн.

Тус их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, эдийн засгийн хувьд жилээс жилд өсөн бэхжиж сургалтын материаллаг бааз өргөжиж, сургалтын орчин сайжирч, сургалт явуулах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Цаашид тавих зорилт

Тус их сургуульд ашиглагдаж буй үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн баркоджуулах, хөрөнгөнд бүртгэлээр болон биетээр тавих хяналтыг сайжруулах, хадгалалт, хамгаалалтын орчинг боловсронгуй болгох, **үргүй зардлыг багасгах, хэмнэлттэй, үр дүнтэй ажиллах**

САНХҮҮГИЙН ХЭЛТЭС